



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2014 оны 10 сарын 10 өдөр

Дугаар 333

Улаанбаатар хот


Хүүхдийн эндэгдлийг магадлан  
хэлэлцэх тухай

Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, Шинэчлэлийн Засгийн үйл ажиллагааны хөтөлбөр дэх “Эрүүл чийрэг монгол хүн” зорилт, Дэлхийн Мянганы хөгжлийн 4 дэх зорилтыг хангах, Эрүүл мэндийн салбарын “Эх, хүүхдийн эрүүл мэндийг дэмжих жил”-ийн хүрээнд зохион байгуулах арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:


1. Нярайн эндэгдлийг магадлан хэлэлцэх зааврыг хавсралтаар баталсугай.
2. Нярайн эндэгдлийн тохиолдол бүрийн нөлөөлөл, шалтгааныг магадлан хэлэлцэж, дүн шинжилгээ хийсний үндсэн дээр авах арга хэмжээ, цаашид зохион байгуулах ажлыг сар бүр төлөвлөж, тайланг улирал бүрийн эхний долоо хоногт багтаан ЭХЭМҮТ –ийн тандалт судалгааны албанд хүргүүлж байхыг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга нарт, дүнг улсын хэмжээнд нэгтгэн хагас жил тутам Эрүүл мэндийн сайдын зөвлөлд танилцуулж байхыг Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар (Я.Буянжаргал), ЭХЭМҮТ (захирал Ш.Энхтөр) –д тус тус даалгасугай.
3. Улсын хэмжээнд 5 хүртэлх насны хүүхдийн гэртээ нас барсан тохиолдол бүрийг магадлан хэлэлцэж, тулгамдсан асуудалд тухай бүр зохих арга хэмжээг авч холбогдох байгууллагуудад тайлагнаж байхыг Эмгэг судлалын үндэсний төв (Г.Уянга), аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга нарт тус тус үүрэг болгосугай.
4. Нярайн эндэгдлийг магадлан хэлэлцэх асуудлыг улсын хэмжээнд зохион байгуулалт, мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар (Я.Буянжаргал), Эрт нярайн тусламж, үйлчилгээний зөвлөх баг, Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв (Ш.Энхтөр)-д тус тус даалгасугай.

САЙД

Н.УДВАЛ



Эрүүл мэндийн сайдын 2014 оны 10  
дугаар сарын 10 ны өдрийн 333 тоот  
тушаалын хавсралт



## Нярайн эндэгдлийг магадлан хэлэлцэх (аудит) заавар

### 1. Ерөнхий зүйл

Нярайн эндэгдлийг магадлан хэлэлцэх буюу аудит нь (цаашид аудит гэнэ) ураг болон нярайд үзүүлсэн тусламж, үйлчилгээг нарийвчлан шүүн хянаж, үнэлэлт дүгнэлт өгөх үйл ажиллагаа бөгөөд тусламж, үйлчилгээг чанартай, зөв зүйтэй явуулах, нас барсан тохиолдол бүрт дүн шинжилгээ, судалгаа дүгнэлт хийж хэлэлцэх үйл ажиллагаа юм. Аудитаар байгууллагын бодлого хөтөлбөр төлөвлөгөө нь зөв боловч хэрэгжих арга зам нь тодорхой бус эсвэл хэрэгжүүлэгчийн мэдлэг ур чадвар хангалтгүй, байгууллагын удирдлагууд нь энэ талын мэдлэггүй, хуучинсаг арга барилтай, гардан ажилбар буруу хийсэн, хүүхдийн биеийн байдлыг үнэлж чадаагүй зэрэг удирдлага, зохион байгуулалт, эмчилгээ, үйлчилгээ, мэдлэг ур чадварт байгаа дутагдлуудыг нэг бүрчлэн тогтоож засаж залруулах шуурхай арга хэмжээ авах, мөн амжилтаа хэлэлцдэг тогтолцоог эрүүл мэндийн байгууллага бүр хэрэгжүүлнэ.

### 2. Нярайн эндэгдлийн аудитын зорилго

Нярайн тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулах, жирэмсэн эмэгтэй болон шинээр төрсөн хүүхдийн амьдрах чадвар боломжийг нэмэгдүүлэх, тусламж үйлчилгээ үзүүлэгч эмч, эмнэлгийн мэргэжилтний ажлын дутагдал болон амжилтыг мэдээлж, тэдний мэдлэг ур чадварыг тогтмол дээшлүүлэх, алдаа дутагдлыг давтагдахаас сэргийлэх ба бүх оролцогч талуудын туршлагыг солилцож, мэдлэгийг дээшлүүлэх зорилготой.

Аудит хийснээр сэргийлэх боломжтой нас баралтыг бууруулах боломж бүрдэнэ.

### 3. Нярайн эндэгдлийн аудит хийх үндсэн зарчим

Эмнэлэг бүрт эндэгдлийг магадлан хэлэлцэх дотоод аудитын комисс байгуулна. Комиссын бүрэлдэхүүнд, эмнэлгийн удирдлагын баг, чанарын мэргэжилтнүүд, статистик бүртгэл мэдээллийн ажилтнууд, сургалт явуулдаг багш нар, анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлэгчид, эх барих, эмэгтэйчүүд, хүүхдийн эмч, эх баригч нярайн эмч сувилагч нарын төлөөллийг оруулна. Шаардлагатай бол холбогдох мэргэжлийн зөвлөхийг урин оролцуулж болно.

Аудитыг дараах үе шатаар явуулна.

- 3.1. Эндсэн тохиолдлуудыг нэг бүрчлэн бүртгэж мэдээллийг цуглуулах; Үүнд:  
*Мэдээллийг цуглуулахдаа Эрүүл мэндийн сайдын 2013 оны 450 дугаар тушаалын СТ-12 маягтыг ашиглана;*
- 3.2. Цуглуулсан мэдээлэлд дүн шинжилгээ хийж дүгнэлт гаргах;

- 3.3. Дүгнэлтийг үндэслэн асуудлыг магадлан хэлэлцэж, асуудлыг нотолгоонд тулгуурлан хэрхэн шийдвэрлэх арга замыг гаргах;
- 3.4. Тухайн эрүүл мэндийн байгууллагын бодлогын түвшинд стратеги, төлөвлөгөө, даргын тушаал шийдвэр, стандарт, заавар, журам зөв эсэхэд дүн шинжилгээ хийх;
- 3.5. Хэрэгжилтийн түвшинд стандарт, заавар, журмыг мөрдөлт, мэргэжилтний ур чадварт дүгнэлт гаргана.

Аудитын хурлыг зохион байгуулахдаа эмч, эмнэлгийн мэргэжилтнийг хэрэгт хийх, сахилга шийтгэлийн арга хэмжээ авах хэрэгсэл болгож болохгүй. Аудитын хурлыг аймаг нийслэлийн Эрүүл мэндийн газар улирал дутам хийж дүгнэлтийг Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвд хүргүүлэх ба тус төв нь нэгдсэн дүгнэлтийг боловсруулан Эрүүл мэндийн яаманд хүргүүлнэ.